



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/100

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Хэрлэн нэгдүгээр сургуулийн барилгыг буулгасантай холбогдуулан “Нямодо трейд” ХХК-ний үйл ажиллагаанд нь доголдол үүсч хэвийн ажиллах боломжгүй нөхцөл байдал тулгарч, 30 хувийн алдагдал хүлээсэн нь ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тул аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу 20 000 000 (хорин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сар бүр олгох дэмжлэгийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010323

Аймгийн Засаг даргын 2022 онд
02 дүгээр сарын 24 өдрийн 8/100
дугаар захирамжийн хавсралт

Дэмжлэг үзүүлэх хуваарь

№	Сар	Мөнгөн дүн
1	1 сар	10 000 000
2	2 сар	10 000 000
	Нийт	20 000 000